



**“МЭДЭЭЛЭЛ-АУДИТ” ХХК**

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“Бүтээлч үйлс” ХК**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар  
болсон санхүүгийн тайлагналын олон улсын  
стандартад нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2022 он

## **Хараат бус аудиторын тайлан**

**“Бүтээлч үйлс” ХК-ийн ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД**

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

**“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК-ийн (цаашид компани гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК-ийн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.**

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулийн эдгээр шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

### **Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Аудиторын зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршино. Ул үндэслэлтэй баталгаа нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь материаллаг болж, эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглаж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоололын ул үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл Аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртлэх олж авсан Аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Санхүүгийн тайлангийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ММНБИ-ийн [monicpa.mn](http://monicpa.mn) сайтад байрлах манай аудитын компанийн холбоосонд байрлуулсан бөгөөд энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь бидний аудиторын тайлангийн хэсэг болно.

#### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг МУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох "Бүтээлч үйлс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ТӨВУУДОРЖ

**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12.31.20	12.31.21
<b>1</b>	<b><u>ХӨРӨНГӨ</u></b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	91,699,726	1,644,529,884
1.1.2	Дансны авлага	12,191,442	1,600,000
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	368,278,745	124,372,445
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	1,439,318,134	1,619,836,315
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>1.1.11</b>	<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>	<b><u>1,911,488,048</u></b>	<b><u>3,390,338,643</u></b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	298,557,798	283,272,737
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>1.2.10</b>	<b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>	<b><u>298,557,798</u></b>	<b><u>283,272,737</u></b>
<b>1.3</b>	<b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>	<b><u>2,210,045,846</u></b>	<b><u>3,673,611,380</u></b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,537,979,744	1,278,871,948
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	158,081,826	151,533,274
2.1.1.4	НДШ-ийн өр	1,898,400	1,451,100
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	28,669,010	28,669,010
<b>2.1.1.13</b>	<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>	<b><u>1,726,628,980</u></b>	<b><u>1,460,525,332</u></b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	734,173,550	2,662,216,584
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	-	-
<b>2.1.2.6</b>	<b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>	<b><u>734,173,550</u></b>	<b><u>2,662,216,584</u></b>
<b>2.2</b>	<b><u>Өр төлбөрийн нийт дүн</u></b>	<b><u>2,460,802,530</u></b>	<b><u>4,122,741,915</u></b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: Төрийн	-	-
2.3.2	Хувийн	89,362,999	89,362,999
2.3.3	Хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	78,920,257	78,920,257
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(419,039,940)	(617,413,791)
<b>2.3.11</b>	<b><u>Эзэмшигчдийн өмчийн дүн</u></b>	<b><u>(250,756,684)</u></b>	<b><u>(449,130,535)</u></b>
<b>2.4</b>	<b><u>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b><u>2,210,045,846</u></b>	<b><u>3,673,611,380</u></b>

**АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	12.31.20	12.31.21
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,425,237,723	816,990,107
2	Борлуулалтын өртөг	938,935,789	473,815,363
3	Нийг ашиг (алдагдал)	486,301,934	343,174,744
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	553,764,795	304,650,692
11	Санхүүгийн зардал	-	236,912,699
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз)	-	14,795
14	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассан олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(67,462,861)	(198,373,851)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(67,462,861)	(198,373,851)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(67,462,861)	(198,373,851)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,362,999	78,920,257	(419,039,940)	(250,756,684)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			0	0
3	Залруулсан үлдэгдэл				-
4	Тайлан үеийн цэвэр ашиг			(198,373,851)	(198,373,851)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласа ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,362,999	78,920,257	(617,413,791)	(449,130,535)

Мэдээлэл Аудит  
ХХК 5  
ВД: 2703939


**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	12.31.20	12.31.21
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,803,096,995</b>	<b>905,705,717</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,568,096,995	898,689,117
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Бусад мөнгөн орлого	235,000,000	7,016,600
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,385,153,676</b>	<b>1,162,946,539</b>
	Ажилчдад төлсөн	100,429,790	60,073,310
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,114,700	17,031,000
	Бараа материал худалдан авахад төлсөн	908,982,580	704,190,323
	Ашиглалтын зардалд төлсөн	40,650,171	8,905,900
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,325,569	9,645,122
	Хүүний төлбөрт төлсөн	195,358,321	236,912,700
	Татварын байгууллагад төлсөн	107,648,054	91,321,000
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	26,644,490	34,867,184
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>417,943,320</b>	<b>(257,240,822)</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,033,500,000</b>	<b>5,660,389,088</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,033,500,000	5,660,373,162
	Төрөл бүрийн хандив	-	-
	Валютын ханшийн зөрүү	-	15,926
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,597,368,546</b>	<b>3,850,318,109</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,480,000,000	3,732,256,966
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	117,368,546	118,060,012
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Валютын ханшийн зөрүү	-	1,131
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,563,868,546)</b>	<b>1,810,070,979</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,145,925,226)	1,552,830,157
5	<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,237,624,953</b>	<b>91,699,727</b>
6	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>91,699,727</b>	<b>1,644,529,884</b>

Тайлан бэлтгэсэн: Шинжээч



С.Наранцэцэг

7-12 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Мэдээлэл Аудит  
ХХК 6  
РД: 2703939

**1. “Бүтээлч үйлс” Хувьцаат компани ба түүний үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл**

“Бүтээлч үйлс” Хувьцаат компани (цаашид “Компани” эсвэл “ХК”)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

Тус компани нь анх 1941 онд налайхын нүүрсний уурхайг түшиглэн байгуулагдаж байсан бөгөөд 1992 оноос “Бүтээлч үйлс” нэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2006 оны 03 дугаар сарын 23-нд 89,362.9 мянган төгрөгийн дүрмийн сантай, 1 гишүүнтэйгээр улсын бүртгэлд бүртгүүлсэн. Улсын бүртгэлийн 2910001001 дугаартай гэрчилгээтэй.

Компанийн хувь эзэмшигчдийн нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 191,180 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн дараах байдалтай байна.

№	Овог	Нэр	Хувьцааны тоо /ширхэг/	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Дамдиндорж	Эрдэнэбилэг	38220	20%
2	Пүрэвжав	Оюунхүү	37221	19%
3	Дамдиндорж	Эрдэнэтулга	33752	18%
4	Бусад хувьцаа эзэмшигч-568 хүн		90013	43%
<b>НИЙТ</b>				<b>100%</b>

ХК-ийн дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчид байх бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн гүйцэтгэх удирдлага дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг
- Дэд захирал М.Нэргүй

**Үндсэн үйл ажиллагаа.** ХК нь компанийн дүрэмд заасан, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн үндсэн үйл ажиллагааны нь дараах чиглэлүүд боловч гол явуулж буй үндсэн үйл ажиллагаа нь бүх төрлийн бэлэн хувцасны үйлдвэрлэл байна.

- Хүнсний дэлгүүр
- Гадаад худалдаа
- Бүх төрлийн бэлэн хувцасны оёдол эрхлэх

**Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Эрчим хүчний зүүн талд өөрийн байранд

Утас: 99091130, 70110147

Э-мэйл: [buteelch\\_uils@yahoo.com](mailto:buteelch_uils@yahoo.com)

Web: [www.buteelch.mn](http://www.buteelch.mn)

**Тайланд хэрэглэсэн толилуулгын валют.** Санхүүгийн тайланд тухайлан өөрөөр заагаагүй бол тайлангийн үзүүлэлтүүдийг Монгол төгрөгөөр илэрхийлнэ.



2. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Касс дахь мөнгө	91,165,529	1,644,325,085
Банкин дахь мөнгө	534,198	204,799
Мөнгөтэй адилтгах хөрөнгө		
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн нийт дүн</b>	<b>91,699,726</b>	<b>1,644,529,884</b>

3. Дансны авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны авлага	12,191,442	1,600,000
ААНОАТ-ын авлага		
НӨАТ-ын авлага		
НДШ-ын авлага		
ХХОАТ-ын авлаг		
Бусад авлага		
<b>Нийт дүн</b>	<b>12,191,442</b>	<b>1,600,000</b>

4. Бусад авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Холбоотой талаас авах авлага		
Ажилчдаас авах авлага		
Бусад талаас авах авлага		
<b>Нийт дүн</b>		

5. Бараа материал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Түүхий эд материал	241,955,720	95,047,677
Дуусаагүй үйлдвэрлэл		
Бэлэн бүтээгдэхүүн	126,323,025	29,324,768
Бараа		
Хангамжийн материал		
<b>Нийт дүн</b>	<b>368,278,745</b>	<b>124,372,445</b>

6. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Урьдчилж төлсөн зардал	1,439,318,134	1,619,836,315
Урьдчилж төлсөн түрээс, даатгал		
<b>Нийт дүн</b>	<b>1,439,318,134</b>	<b>1,619,836,315</b>

7. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	362,243,349	362,243,349
ХЭ-Барилга байгууламж	(87,254,448)	(96,312,533)
Машин, тоног төхөөрөмж	40,290,000	40,290,000
ХЭ-Машин, тоног төхөөрөмж	(22,198,001)	(26,226,977)
Тээврийн хэрэгсэл	22,000,000	22,000,000
ХЭ-Тээврийн хэрэгсэл	(16,521,101)	(18,721,102)
<b>Нийт дүн</b>	<b>298,559,798</b>	<b>283,272,737</b>

8. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>Нийт дүн</b>	<b>0</b>	<b>0</b>

**9. Дансны өглөг**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны өглөг /Хугацаандаа байгаа/ Цалингийн өглөг	1,537,979,744	1,278,871,948
<b>Нийт дүн</b>	<b>1,537,979,744</b>	<b>1,278,871,948</b>

**10. Татварын өр**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ өглөг	-	-
НӨАТ өглөг	157,167,906	150,777,794
ХХОАТ өглөг	913,920	755,480
НДШ-ийн өглөг	1,898,400	1,451,100
<b>Нийт дүн</b>	<b>159,980,226</b>	<b>152,984,374</b>

**11. Богино хугацаат зээл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Төлөгдөх хугацаандаа байгаа Хугацаа хэтэрсэн		
<b>Нийт дүн</b>		

**12. Урьдчилж орсон орлого**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
УОО	28,669,010	28,669,010
<b>Нийт дүн</b>	<b>28,669,010</b>	<b>28,669,010</b>

**13. Бусад богино хугацаат өр төлбөр**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Санхүүгийн түрээсийн өглөг Бусад өглөг		
<b>Нийт дүн</b>		

**14. Урт хугацаат зээл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Урт хугацаат зээл	734,173,550	2,662,216,584
Бусад		
<b>Нийт дүн</b>	<b>734,173,550</b>	<b>2,662,216,584</b>

**15. Бусад урт хугацаат өр төлбөр**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хойшлогдсон татварын өглөг		
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>

**16. Эздийн өмч**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Өмч		
а/ төрийн		
б/ хувийн	89,362,999	89,362,999
Халаасны хувьцаа		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	78,920,257	78,920,257
Тайлант үеийн хуримтлагдсан ашиг /алдагдал/	-419,039,940	-617,413,791
<b>Дүн</b>	<b>-250,756,684</b>	<b>-449,130,535</b>

**17. Борлуулалтын орлого**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Борлуулалтын орлого	1,425,237,723	816,990,107
<b>Нийт борлуулалтын өртөг</b>	<b>1,425,237,723</b>	<b>816,990,107</b>

**18. Борлуулалтын өртөг**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	938,935,789	473,815,363
<b>Нийт борлуулалтын өртөг</b>	<b>938,935,789</b>	<b>473,815,363</b>

**19. Бусад орлого**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хүүний орлого	0	
Бусад орлого		
<b>Бусад орлогын дүн</b>	<b>0</b>	<b>0</b>

**20. Борлуулалт ба ерөнхий удирдлагын зардал**

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
Ажиллагсадын цалин	87,000,000.00	70,860,000.00
Аж ахуй нэгжээс төлсөн НДШ	5,853,600.00	8,870,400.00
Томилолтын зардал	958,909.09	-
Бичиг хэргийн зардал	780,218.17	1,293,636.38
Шуудан холбооны зардал	2,777,589.07	3,885,640.87
Даатгалын зардал		
Ашиглалтын зардал	40,650,171.10	9,283,311.56
Харуул хамгаалалтын зардал		3,731,000.00
Элэгдэл хорогдлын зардал	15,326,938.08	15,285,061.20
Түрээсийн зардал	132,492,411.29	125,972,012.50
Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал		
Тээврийн зардал		
Шатахууны зардал	2,325,569.09	9,645,216.39
Зар сурталчилгааны зардал	150,000.00	2,009,545.45
Зээлийн хүүний зардал	195,358,321.00	236,912,698.71
Түүхий эд материалын зардал	27,528,294.10	29,565,522.30
Бусад зардал	42,562,773.82	24,249,344.86
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>553,764,795</b>	<b>541,563,390</b>

**21. Татварын зардал**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ	0	0
<b>Нийт дүн</b>	<b>0</b>	<b>0</b>